"Монгол цэргийн одор", орчин цагийн Зэвсэгт хvчин байгуулагдсаны 98 жилийн ойг угтаж "Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хvчнийг бvрдvvлж бэхжvvлэхэд тулгамдаж буй зарим асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал оноодор YБХИС-д боллоо.

Хурлыг Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан технологийн зовлолийн дарга Т.Дуламдорж нээж хэлсэн vгэндээ "Монгол цэргийн одрийг угтаж, БХЯ, ЗХЖШ, YБХИС, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэнгээс хамтран Зэвсэгт хvчний омно тулгамдаж буй асуудлаар эрдэм шинжилгээний хурал хийдэг уламжлал тогтоод 10 жил болж байна. Энэ удаагийн сэдэв маш оргон хvрээнийх. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хvчний хогжлийн стратегийг "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын vндэс" баримт бичигт тодорхойлсон" зэргийг онцлов. Yvний дараа цэргийн эрдэмтэн судлаач, удирдах албан тушаалын генерал, офицерууд мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хvчин гэдэг оороо ямар ойлголт вэ, тvvнийг бэхжvvлэх арга зам зэрэг илтгэл тавьж, хэлэлцvvлэв.